

НЭВТРҮҮЛЭГ, ХӨТЛӨГЧДӨӨС АЖИГЛАСАН
ХЭЛ, ЯРИАНЫ СОЁЛД ХОЛБОГДОХ ЗАРИМ ЗҮЙЛ

Л.Амарзаяа*

* МҮОНТ, хэл бичгийн ухааны доктор (Ph.D.)

Түлхүүр үг: хэлний хэм хэмжээ, хэл ярианы соёл, СНХ (сэтгүүлч, нэвтрүүлэгч, хөтлөгч)-ийн мэргэжлийн шаардлага.

Хүн хэл, ярианы соёлыг гэр бүл, хүрээлэн буй орчин, сургууль, олон нийтийн газар, найз нөхөд, багш нар, хүндэлж явдаг (ялангуяа олны танил) хүн, ОНМХ-ээс үлгэр дуурайл авч, сурч, хэрэглээ болгож байдаг. Урлаг соёл (дуу хөгжим, дүрслэх урлаг гэх мэт)-ын нөлөө ч бараггүй юм.

Аливаа юм бүхэн тодорхой хэм хэмжээтэй байдаг. Хэлэнд ч бас бий. 2003 оны 5-р сарын 15-ны өдөр баталсан 3 бүлэг, 8 зүйл бүхий “Төрийн албан ёсны хэлний тухай хууль”-ийн II бүлэгт Төрийн албан ёсны хэлийг хэрэглэх тухай заажээ. Хуулийн 5.16-д “Төрийн албан ёсны хэлээр гарч байгаа олон нийтэд зориулсан хэвлэл, мэдээлэл нь орчин цагийн монгол утга зохиолын хэлний хэм хэмжээ, нэр

томъёог баримтална” гэжээ. Бодит байдал дээр ямар байгааг зарим жишээгээр авч үзье.

Хөтлөгч: Үгийн сонголт, зөв хэрэглээ нь хөтлөгчийн ур чадварын хамгийн чухал илэрхийлэл байдаг. Харин одоо манай радио, телевизүүдийн хөтөлбөрт үгийн сувдыг түүн байж, үзэгч, сонсогчдодоо багц баглаагаар өргөн барих нь ховорджээ. Тийм ч болохоор ярианы ядмагхан хэдэн үгэнд эргэлдэх болж, ялангуяа FM буюу хэт богино долгионы радионуудаар ярьж буй хөтлөгчид хэл, ярианы соёлгүй, ёс зүйн хувьд ч тааруу байна.

“Уучлаарай, өнөөдөр миний хоолой жаахан сөөчихөж. Өчигдөр шоудаад, юу яасан л даа...” гэж хөтлөгч радио-гоороо ярьсан байна. Энэ тухай Э.Энгүүн бичихдээ “Шоудах бус шоу нэвтрүүлэг санаачилснаа гайхуулан нэвтрүүлбэл сонирхолтой баймаар”¹ гэжээ. Эндээс харахад хөтлөгчид тавьдаг үндсэн шаардлага хангагдаагүй байна.

Радио, телевизийн сэтгүүлч, нэвтрүүлэгч, хөтлөгч хүнд дараах гурван шаардлага нэн чухал. Үүнд:

- Хөтлөгчийн соёл, эрүүл ахуйн шаардлага (хэл, яриа, харилцаа, хувийн, эфирийн соёл болон дуу хоолойн эрхтний эмгэггүй, харах, сонсох, тулгуур эрхтэн эрүүл байх, сэтгэл зүйн байдал).

- Ёс зүйн (ёс суртахуун, төлөвшил) шаардлага.

- Мэргэшсэн байх (радио, телевиз, тайзны хөтлөлт, цаашилбал нэвтрүүлгийн төрлөөс шалтгаалан мэргэшэх) шаардлага багтана. Одоогоор Радио, телевизийн сургууль энэ чиглэлд түлхүү ан-

хаарч, сургалтын хөтөлбөртөө тусгажээ. Бусад их, дээд сургууль, сургалтын төвүүд ч бас анхаарч эхэлж байгаа нь сайшаалтай. Японд нэвтрүүлэгч бэлтгэдэг тусгай сургууль байдаг. Тэр сургуулийг төгссөн хүн бүхэн сайн нэвтрүүлэгч болдоггүй бөгөөд гагцхүү авьяас чадвар, ур зүй, хичээл зүтгэлтэй хүнийг сонгодог байна. Японы NHK телевизийн нэвтрүүлэгч Миада Осаму “Жил бүр шинээр 25 хүнийг нэвтрүүлэгч болгож авдаг. Тэд хэдэн мянган хүнтэй өрсөлдөж энэ

эрхийг авна”² гэж ярьсан нь энэ мэргэжилд хичнээн өндөр шалгуур тавьдгийг илтгэнэ. Харин манайд тийм шалгуур үзүүлэлт гэж бараг алга. Бөөрөнхий хэллэгтэй, сөөнги хоолойтой, дуран авайтайгаа ч харьцаж чадахгүй хүмүүс телевиз, радиод “Хөтлөгч” гэж дуудуулж байгаа нь харамсалтай. Тэдэнд

мэргэжлийн гэх үзүүлэлт байдаггүй. Тиймээс ч “зарим сонсогчдод радиогийн эфирт ажиллахад ядах юмгүй мэт санагддаг биз. Урт нуршуу яриатай хөтлөгчийн мэдлэг дулимаг санагддаг бол тэдний байр суурийг эзэлж болох”³ тухай хааяахан сануулж, идэвхтэн-хөтлөгч, сонир-

хогчдын дунд уралдаан тэмцээн зохиодог ч онцын өөрчлөлт ажиглагдахгүй л байна. “Хэлэх амархан, хийх хэцүү” гэдгийн тод жишээ энэ билээ.

Зохих хэм хэмжээ, шаардлагад нийцэхүйц байхын тулд сурах, сургах хэрэгтэй. Нэн түрүүнд хэл, ярианы соёл, зөв илэрхийлэл, хэрэглээ чухал байна. Тухайлбал монгол хэлний “ба”, “бөгөөд”, “буюу” холбоос нь утга илэрхийлдэг. Нэг зүйлийг хоёр өөр байдлаар тайлбарлах тохиолдолд “буюу” гэсэн холбоосыг хэрэглэнэ. Гэтэл UBS

«

Үгийн сонголт, зөв хэрэглээ нь хөтлөгчийн ур чадварын хамгийн чухал илэрхийлэл байдаг. Харин одоо манай радио, телевизүүдийн хөтөлбөрт үгийн сувдыг түгнэж, үзэгч, сонсогчдодоо багц баглаагаар өргөн барих нь ховорджээ. Тийм ч болохоор ярианы ядмагхан хэдэн үгэнд эргэлдэх болж, ялангуяа FM буюу хэт богино долгионы радионуудаар ярьж буй хөтлөгчид хэл, ярианы соёлгүй, ёс зүйн хувьд ч тааруу байна.

»

телевизийн "Бизнес мэдээ"⁴-гээр эмэгтэй хөтлөгч "Тун удахгүй болох эмэгтэйчүүдийн баяр буюу эрэгтэйчүүдийн баяраар" ямар нэгэн бараа, бүтээгдэхүүн хямдарч байгаа тухай мэдээлэв. Холбоосыг буруу хэрэглэснээс болоод хоёр өөр баярыг нэг ойлголт болгочихож байгаа юм. Уг нь эмэгтэйчүүдийн баяр төдийгүй, эрэгтэйчүүдийн баяраар ч хямдрал зарлаж байгааг үзэгчдэд хэлэх гэсэн бололтой.

Хөтлөгч буруу уншсанаас утгын алдаа гарч, сонсогч, үзэгч төөрөлдөх нь цөөнгүй. Жишээ нь "Энэ нь тус компанийн жолооч танд зориулж байгаа бэлэг юм" гэсэн өгүүлбэрийг уншихдаа хөтлөгч "...тус компанийн жолооч танд" гэж азнаа (зогсосхийлт) авав. Ингэснээр жолооч нь тус компанийн хүн юм байна гэж ойлгогдож байна. Гэтэл тус компаниас нийт жолооч нарт зориулж хямдрал зарлан бэлэг барьж байгаа тухай мэдээлэл юмсанж.

Заримдаа үг орхиж ярих нь утгын алдаа болдгийг СНХ-чид анзаарахгүй байна. Ганцхан жишээ дурдахад "40 мянган айлын орон сууц"-ны тухай мэдээлэхдээ "40 мянган орон сууц" болгоод л ярьчихдаг болжээ.

Радиогийн сонсогчид телевиз үзэж байгаа шигээр бодитой харах боломжгүй тул ярьж буй хүн үгээр зураглаж, дүрслэн ярих чадвартай байвал зохино. Сэтгүүлч, хөтлөгчийн дүрслэлээр сонсогч ургуулан бодож, дүрслэл

төсөөллийг бий болгодог онцлогтой. Энэ тухай судалгаанд оролцсон нэгэн сонсогч "Үндэсний бөхийн барилдааныг радиогоор тайлбарлаж байхдаа барилдаж буй бөхчүүд ямар өнгийн зодог шуудаг өмссөн зэргийг оруулан тайлбарлуулах саналтай байна. Монгол улсын арслан Бадамсэрээжид гуай нэлээд эрт ингэж тайлбарладаг байсан. Энэ нь их нийцтэй сонсогддог"⁵ хэмээн санал хүсэлтээ бичсэн нь радиогийн хөтлөгчдийн хэл, ярианы чадварт холбогдож байгаа юм.

TV-9 телевизийн "Энэ өглөө"⁶ нэвтрүүлэгт МУГЖ Вандан, Дуламсүрэн нарыг зочноор урьж оролцуулав. Хөтлөгч тэдэнтэй уулзаж байгаагаа их л олзуурхаж "Би энэ хүмүүстэй нүүрээрээ уулзаж байгаадаа баяртай байна" гэхив. Уг нь "Нүүр тулан уулзах" гэдэг хэлцийг хэрэглэх гэсэн болов уу. Тэрээр цааш "Вансэмбэрүү" дууны клипийг үзүүлсний дараа "Хөөрхөн клип болсон байна" гэж хэнэггүйхэн дүгнэж суулаа. Энд "Хөөрхөн" гэдэг тодотгол огт тохирсонгүй. Хөтлөгч хүн урлаг судлаач, мэргэжилтний нэрийн өмнөөс дүгнэлт хийх биш, харин хувийн санал сэтгэгдлээ хэлж болдог.

Сэтгүүлч, хөтлөгчид монгол хэлнийхээ үгийн утга, үгийн санг мэдэж, ашиглаж, хэрэглэж сурах хэрэгтэй байна. Эрдэмтэн М.Базаррагчаа "сарсайх-сарзайх, сэрсийх-сэрзийх, сөрсийх-сөрсзийх, сорсойх-сорзойх гэх мэт дүрслэх үгийн "с" авиатай үгс нь

нимгэн, хатуу юмын хөндлөөшөө үргэлжлэн нэг чигт хөдлөх утгыг заадаг бол, “з” авиатай үг хатуу юмын өндрөөшөө тал тал тийшээ чиглэсэн утга илтгэж байна”⁷ гэжээ. Энэ мэтээр нарийвчилж авианы утга ялгах тухайд биш гэхэд хэлж буй үгийнхээ утга, мөн чанарыг мэддэг байхын чухлыг дээрх жишээ нотолж байна.

Хэрэглээний талаас нь авч үзвэл, “хөөрхөн” гэдэг үг нь “сайхан, аятайхан, дажгүй, царайлаг, нүдэнд дулаахан” гэх мэт үгтэй ойролцоо утгатай юм. Гэвч утгын хувьд ялгаатайг санаж, аль ончтойг сонгох шаардлагатай билээ. “Хөөрхөн, царайлаг, нүдэнд дулаахан” зэрэг нь харахуйн сэрэл мэдрэмжинд тусах хэлбэр шинжтэй байдаг бол сайхан, аятайхан, дажгүй зэрэг үг нь бүхэл цогцоор нь илэрхийлсэн агуулгыг тодотгодог. Тэгэхлээр клип нь “Өхөөрдөм хөөрхөн хүүхэд” биш учраас “Сайхан, аятайхан уран бүтээл” байж болох юм.

UBS телевизээр гарч буй “Miss and Mister” реалити шоуг хоёр хөтлөгч хөтөлдөг. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн өдрөөр⁸ эрэгтэй хөтлөгч эмэгтэйгээсээ энэ үдэш ямар зочин урьсныг асуув. Хөтлөгч Шинэбаяр “Шөнө дөлөөр аймаар алдартай жүжигчин ирсэн” гэж их л хүч оруулж, үзэгчдийг татах гэсэн байдалтай хариуллаа. Харин баярын үдэш, харанхуйд “Аймаар зочин” оролцох сургаар би сувгаа сольчихов. Хэдийгээр “Аймаар” гэдэг үгийн хэрэглээ хаа сайгүй тархсныг

мэддэг ч тухайн агшинд бие жихүүцээд явчихсан даа.

“Аймаар”-тай бас нэгэн жишээ. 2007 оны 6-р сарын 30-ны өдөр 20:40 цагт “Пентатоникийн улаан хивсний ёслол”-ыг UBS сувгаар шууд дамжуулав. Дуучин Өөдөөтэй хөтлөгч ярилцахад Өөдөө “*Чи ч гэсэн аймаар гоё харагдаж байна*” гэлээ. Надад бол хөтлөгчөөс айгаад байх юмгүй, харин ч аятайхан хувцасласан харагдав.

“FOX2P гэх хэл ярианы ген хүмүүст ам болон багалзуурын булчинг чадмаг удирдах боломж олгодог”⁹ гэж судлаачид үздэг байна. Хүн бүрт байдаг бие махбодийн энэхүү ген нь хэлж ярих үйлтэй холбогдох бөгөөд бодож сэтгэх, уран яруу илэрхийлэх нь хэл, ярианы соёл, боловсрол, ур чадварын асуудал болно.

“Life” радиогийн хөтлөгч Жошуа, Аманда, Тамара нарын хэл, ярианд бүдүүлэг, этгээд хэллэг давамгайлдаг. Үүгээрээ тэд радио болон хөтлөгчийнхөө өвөрмөц онцлогийг тодорхойлдог гэнэ. Үүнийг буруу, байж болшгүй гэж бас болдоггүй. Учир нь онцлог, шинэ, сонин содон зүйлд залуус хошуурдаг нь аль ч цагт байдаг л үзэгдэл. Гэвч “Хэл бол үс, хувцасны нэгэн адил моодны аяс, урсгалд өртөмтгий байдаг. Гэвч аливаа моодны хэллэг, үгэнцэр тун удахгүй хүмүүсийг залхааж эхэлдэг. Тиймээс өөрийн бичгийн хэв маягт ямагт үнэнчээр

хандаж, моодыг аялдан дагагч биш, түүнийг журамлагч, зөв голдиролд оруулагч байсан нь дээр"¹⁰ гэсэн гадны судлаачийн дүгнэлттэй санал нийлж байна. Бид ч бас монгол хэлнийхээ хэм хэмжээнд нийцүүлж хэл, ярианы соёлоо цэвэр ариун байлгах учиртай.

Оролцогч: NTV телевизийн "Таныг сонжъё" нэвтрүүлгийн нэгэн дугаарыг (2008.02.22. 19:29) АНУ-аас бэлтгэжээ. Хөтлөгч Халиун, хөгжмийн зохиолч, дуучин Чинбат нар их л чөлөөтэй, энгийн ярилцлага өрнүүлж, сонирхол татав. Даанч Чинбатын ярианаас *"Намайг зориод ирсэнд чинь аймаар их баярлаж байна", "Аймаар гоё мэд рээд...", "Аймаар их мөнгө үрдэг"* гэх мэтээр өнөөх л "Аймаар" гэдэг үгийг олонтаа давтсан нь дарамттай санагдав. Энэ үгийг шууд утгаар нь тайлбарлавал айсан хүн яаж баярлах билээ, үнэхээр аймаар байсан юм бол яаж гоё байх билээ дээ.

Эндээс харахад олны танил, ялангуяа өсвөр, залуу үед үлгэр дуурайл болж байдаг хүмүүс ярилцлага, сурвалжлага өгөхдөө хянамгай байж, өөрийгөө илэрхийлж байгаа хэл, яриагаа анхаарах нь зүйтэй санагдана. Дашрамд дурдахад нэвтрүүлэг, тоглолт, концерт зэрэг үйл ажиллагааг сонирхолтой болгох үүднээс олны танил хүмүүсээр хөтлүүлэх нь бий. Жишээ нь Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэн, Төрийн хошой шагналт хөгжмийн зохиолч Н.Жанцанноров,

Соёлын тэргүүний ажилтан дуучин Х.Болормаа, Ж.Алтанцэцэг зэрэг уран бүтээлчид хөтлөгчийн үүрэг гүйцэтгэх тухай дуулдаж байсан. Зарим дуучид чадварлаг хөтлөгч болж чаддаг. Соёлын тэргүүний ажилтан, жүжигчин Өлзийхүү, дуучин Өөдөө, Ундрал, В.А.Т гээд "Жүжигчин-хөтлөгч", "Дуучин-хөтлөгч" гарч ирэх болов.

В.А.Т-гийн хөтөлсөн "Celebrity blue party" (UBS сувгаар гарсан) нэвтрүүлэг анхаарал татав. Тэр үдэшлэгт ирж буй хүмүүс бүгд цэнхэр өнгийн өмсгөлтэй байх учиртай юм байна. Хөтлөгч В.А.Т сэтгүүлч Дашзэвэг (DZ man)-ээс *"Сэтгэл ямар өндөр байна?"* гэж асуулаа. Бас нэгэн хамтлагийнхантай уран бүтээлийн талаар товч ярилцаад *"Ямар болсныг үзэгчид оношлогоо онологоог тогтоох байх"* гэв. Хөтлөгч *"Таны сэтгэл хир өндөр байна?"*, *"Сэтгэгдэл ямар байна?"* гэсэн санаагаар асуух гэсэн байх. Харин оношлогоог голдуу машин техник, эмчийн үзлэг, шинжилгээнд хамааруулж хэрэглэдэг. "Онологоо" гэдэг үгийг анх удаа сонслоо. "Төрийн албан ёсны хэлний тухай хууль"-ийн 5.18-д "Төрийн албан ёсны хэлэнд дүйх үг, нэр томьёо байхад гадаад үг, нэр томьёо хэрэглэхийг хориглоно" гэжээ.

"Хүүхэд 16 нас хүртлээ эх хэлнийхээ 60 хувийг эзэмшдэг" тухай доктор, профессор Л.Галбаатар нэгэнтээ ярьж байсан. Радио, телевизийн сонсогч, үзэгчдийн багагүй хувь нь хүүхдүүд

байдаг. Тэд үргэлж л "Аймаар", "Аягүй" гэдэг сөрөг утгатай, ядуувтар үгийн хэрэглээг сонсч, сурч, хэрэглэж байна. Энэчлэн олон байдлаар бид сонсогч, үзэгчдийг дагуулж, сургаж, нөлөөлж байдаг. Гэвч тэд үг авамтгай, сайн сурагчид байдгийг өөрийн жишээн дээр онцолъё. Оролцогч утасны цаанаас "Би Баагий байна аа" гэхийг сонсоогүй хөтлөгч үгүй байх. Үндсэн сэдвээ ярихаас өмнө сонсогч бид хоёрын дунд ихэнхдээ ийм яриа өрнөдөг. Гэхдээ цаг аваад байдаггүй юм.

- Та өөрийгөө танилцуулна уу?
- Баагий байна аа.
- Уучлаарай, Баагий гэдэг чинь таныг авгайлж байгаа, гэр бүл, найз нөхдийн тань дууддаг нэр байхаа даа?

- Аан хн, тийм ээ.
- Аав ээжээс хайрласан нэрээ хэлэх хэцүү байна уу?

- Яах юм бэ.
- Нэрээ бүтнээр нь биш гэхэд нэг үеэр нь хэлж болно биз дээ? Намайг Амарзаяа гэдэг. Гэхдээ би Амараа, эсвэл Заяа гээд танилцуулчихдаг л даа. Бидний яриаг олон хүн сонсож байгаа шүү дээ, хоёулаа нэрээ мэдэлцэж, соёлтой харилцъя, болох уу? (Зарим тохиолдолд оролцогч утсаа тасалчихна. Энэ үед сонсогч хөтлөгчийг биш оролцогчийг нэрээ хэлэхээс татгалзсаных нь төлөө зэмлэх нь олонтаа. Таслаагүй бол яриа-ийн үргэлжилнэ)

- За за тэгье. Намайг Батболд гэдэг.

- Баярлалаа, Батболд оо.

Үүнээс хойш нэвтрүүлэгт оролцохыг хүссэн сонсогчид надаар гуйлгахгүйгээр шууд л нэрээ хэлж, танилцуулаад ярилцдаг. Ийм маягаар лав л манай сонсогчид нэрээ хэлэхээсээ татгалздаггүй бас хаанаас оролцож байгаагаа ч нуудаггүй. Энэ бол соёл. Соёлтой, эелдэг харилцахыг бүгд л хүсдэг. Саяын жишээ бол хөтлөгч оролцогчоос соёлтой байхыг хүссэн хүсэлт. Сонсогч, үзэгч ч бас соёлт харилцааг сэтгүүлч, хөтлөгч, нэвтрүүлэгчээс хүсэмжилдэг. Жишээ нь Нийслэлийн XIII дунд сургуулийн багш Х.Балдан-Очир нэвтрүүлэгч, хөтлөгчдийн хэл, ярианы соёлын тухай бичихдээ:

- "Залуу бөхчүүдийн барилдаан боллоо" гэдгийг "залуу бөхчүүд барилдлаа",

- "баярын мэнд дэвшүүлж байна" гэдгийг "дэвшүүлье",

- "тоглолтонд урьж байгаа аж" гэдгийг "урья" гэх мэтээр илэрхийлбэл чихэнд наалдацтай бууж, цаг хугацаа хэмнэх тухай саналаа илэрхийлж байжээ¹¹.

Сурталчилгаа: Радио телевизийн сурталчилгааны хэл, ярианы соёлд холбогдуулан ганц жишээг дурдъя. Монголын "Халуун сэтгэл" нэртэй уран сайхны киноны телевизийн сурталчилгаанд нэг хүү "Аягүй гоё кино байна" гэхэд дараагийн эмэгтэй "Сайхан кино болж" гэлээ. Гоё кино болсныг хүүгийн

хэлснээс ойлголоо. Харин аягүй (хөг аялгуу байхгүй) юм байх даа гэж бодож болохоор байна. Бидний хар ярианы хэрэглээнд “аягүй, аймаар” гэдэг нь дараагийнхаа үгийг улам хүч оруулж тодотгодог болжээ. Гэтэл жинхэнэ бодит утгаараа бол ая эгшиг үгүй бол аягүй, сонсголонгүй гэсэн санаа болох билээ. Залуу үеийн төлөөлөл нь уг киног “Аягүй гоё” гэж тодотгож байхад дунд эргэм насны эмэгтэй “Сайхан кино” хэмээн онож хэлж байгаа нь хэл, ярианы соёлын хэмжүүр аль үе, насныханд ямар байдалтай байгааг илтгэх жишээ юм.

Орчуулга:

“Хэлийг зөв дуудаж, хэм хэмжээнд нийцүүлэн ярих нь бодол санааг үнэн зөв, тод илэрхийлэх түлхүүр болдог”¹² тухай мэргэжилтнүүд онцолдог. Энэ нь эх хэлээрээ ярьж, харилцаж буй сэтгүүлч, хөтлөгч төдийгүй орчуулагч, орчуулгыг уншиж байгаа хүмүүст хамааралтай юм. Учир нь буруу хэлж, хэрэглэдгээс болоод үзэгч төөрөгдөлд орох нь цөөнгүй. Жишээ нь TV-5 телевизээр гарсан “Далжаагийн хавар” цуврал кинонд хөтлөгчийн ажлын онцлог, авхаалж самбаа гээд олон зүйлийг өгүүлдэг. Уг киноны XII ангийг

(2008.03.02. 21:24) үзэж суутал нэг дүр нь “Ямар юм бол гэж их мэдэхийг хүссэн” гэлээ. Бидний “Буруу ярьж зөв ойлгодог” сэтгэлгээгээр бол ойлгомжтой л байна. Эхний хувилбараар бол “Ямар юм байх бол? гэж мэдэхийг их хүссэн” гэж ойлгож болно. Эсвэл “Ямар их зүйл мэдэхийг хүссэн”-ээ хэлсэн байж ч болох юм.

«

“Хэлийг зөв дуудаж, хэм хэмжээнд нийцүүлэн ярих нь бодол санааг үнэн зөв, тод илэрхийлэх түлхүүр болдог” тухай мэргэжилтнүүд онцолдог.

Энэ нь эх хэлээрээ ярьж, харилцаж буй сэтгүүлч, хөтлөгч төдийгүй орчуулагч, орчуулгыг уншиж байгаа хүмүүст хамааралтай юм. Учир нь буруу хэлж, хэрэглэдгээс болоод үзэгч төөрөгдөлд орох нь цөөнгүй.

»

Уг киноны дараагийн ангид (2008.03.08. 10:15) “Хоёр ээжүүд маань нэг тал болжээ” гэв. Ийм орчуулгын жишээгээр бол “Хоёр үхрүүд”, “Таван хар ямаанууд”, “Хоёр нүднүүд” гэх мэтээр хэлэх болж байна. Монгол хэлний өгүүлбэрт олон

тооны нөхцөлтэй үгийн ард олон тооны хэлбэртэй үг хэрэглэдэггүй. “Хоёр ээж” гэхэд хүүхэн, хархүү хоёрын ээж болох нь тодорхой. Эсвэл “Ээжүүд маань нэг тал болжээ” гэхэд бас л ойлгомжтой байна.

Яг одоогоор үзэгчдийн сонирхон үзэж байгаа “Хоёр Таня” (2008.03.07. 23:54) кинонд дээрх алдаа давтагдав. “Таарсан ч алиалагчууд бол доо?” гэсэн өгүүлбэр чих дэлсээд авлаа. Бас л олон тооны нөхцлийг зөв сонгох тухай байна. “Чууд”, “чүүд”, “нар”, “с”, “д” нь олон тооны нөхцөл мөн. “Эхчүүд,

эмэгтэйчүүд, монголчууд, бөхчүүд" гэх мэтээр нэр үгэнд "чууд", "чүүд"-ийг залгаж болох боловч зарим нэр үгэнд "алиалагчууд, багшчууд, үзэгчүүд, сонсогчууд, сэтгүүлчүүд, хөтлөгчүүд, жолоочууд" гэх мэтээр хэрэглэж болдоггүй. "Алиалагч нар", "Алиалагчид" гэхэд болно.

МҮОНР-ийн гадаад мэдээнд "Сүүлийн долоо хоногт хоёр орны харилцаа бага зэрэг бүлээрэх хандлагатай болж байна", "...ширүүн өрсөлдөөн болно гэдгийг яалт ч үгүй тэмдэглэж байна", "...өрнөдийнхний эсрэг хатуу байр суурь баримтлагчдын байр суурийг улам бэхжүүлэх болно гэж мэдэгджээ" гэсэн өгүүлбэр сонсогдов.

- "Халуурах, бүлээрэх" гэдэг үг "нааштай хандах, дотносох" гэдэгтэй утга дүйж болох уу даа? Эсрэгцүүлээд бодвол бүлээрэх хандлага байгаа юм чинь хүйтрэх, сэрүүсэх хандлага бас байж болох нь.

- Бас яалт ч үгүй тэмдэглэж байгаагийн цаана хүчинд автаж, гарцаагүй байдалд орсон байх магадлалтай. Гэтэл мэдээний агуулга нь Каннын кино наадмын тухай байна. Зүй нь "...ширүүн өрсөлдөөн болох нь тодорхой байна" гэвэл энгийн, ойлгомжтой сонсогдоно.

- Өгүүлбэрт нэг үгийг давтан хэрэглэх нь ялангуяа радиогийн хэлийг сонсголонгүй болгодог гэмтэй. Монгол хэл ижил, ойролцоо утгатай үгээр баян. Тэгэхээр "...өрнөдийнхний эсрэг хатуу

байр суурь баримтлагчдын үзэл бодлыг улам бэхжүүлэх болно гэж мэдэгджээ" гэхэд болмоор санагдана.

Сүүлийн үед гадаад хэлний боловсролтой байхыг чухалчилж байгаа нь сайн хэрэг боловч хэрэв ОНМХ-ийн ажилтан л юм бол "Төрийн албан ёсны хэлний тухай хууль"-ийн 5.17-д заасанчлан "Төрийн албан хаагч, олон нийтийн хэвлэл, мэдээллийн ажилтан нь монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёог хэрэглэх зохих төвшний мэдлэг, чадвартай байна" гэсэн шаардлагад нийцүүлэн ажил үүргээ гүйцэтгэх учиртай юм.

Энэ бүгдийг дүгнэн үзвэл,

- Манай радио, телевизүүдийн нэвтрүүлэг, хөтлөгчдийг ажиглахад хэл, ярианы соёлд холбогдох доголдол их гарах болов.

- Радио, телевизүүд сэтгүүлч, нэвтрүүлэгч, хөтлөгчдөд тавих шаардлага, хэм хэмжээг мөрддөггүй бөгөөд "Төрийн албан ёсны хэлний тухай хууль" хэрэгжихгүй байгаа нь илэрхий юм.

- Энэ нь радио, телевизийн уран бүтээлчид төдийгүй сонсогч, үзэгчийн буюу олон нийт, ялангуяа хүүхэд, өсвөр үе, залуусын хэл, ярианы соёл, хэрэглээнд сөргөөр нөлөөлж байна

- Хэл шинжлэл, сэтгүүл зүй, ОНМХ, урлаг, соёл, хуулийн байгууллагуудын мэргэжилтэн, эрдэмтэн судлаачид энэ асуудалд анхаарал хандуулж, засч залруулах, сургаж,

хөгжүүлэх, хяналт тавих, хариуцлага тооцоход чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулах шаардлагатай юм.

Ишлэл

- ¹ "Өнөөдөр" сонин. 2005.04.19. №092/2441.
- ² "Өнөөдөр" сонин. 2004.09.20. №220/2264.
- ³ "Өнөөдөр" сонин. 2005.06.08. №134/2483.
- ⁴ UBS телевизийн "Бизнес мэдээ". 2008.03.07.22:32
- ⁵ Монголын Үндэсний радио 2005 оны I улирлын сонсогчдын судалгааны тайлан.
- ⁶ TV-9 телевизийн "Энэ өглөө" 2008.01.31. 08:56.
- ⁷ Б а д а м д о р ж Д. 2001. Монгол хэлний утга судлал. УБ. 21 дэх тал.
- ⁸ UBS телевизийн "Miss and Mister" реалити шоу. 2008.03.07. 22:35.
- ⁹ "Өрхийн үйлдвэрлэл" сэтгүүл. 2003. № 06. 26 дахь тал.
- ¹⁰ Р э н д а л л Д. 2002. Яаж сайн сэтгүүлч болох вэ? УБ. 19 дэх тал.
- ¹¹ "TV and R хөтөлбөр" сонин. 2004 он. №42/211.
- ¹² А в а н е с о в Р. И. 1972. Русское литературное произношение. М., с. 21.

Ашигласан материал

1. Б а д а м д о р ж Д. 2001. Монгол хэлний утга судлал. УБ.
2. Р э н д а л л Д. 2002. Яаж сайн сэтгүүлч болох вэ? УБ.

3. Монголын Үндэсний радио 2005 оны I улирлын сонсогчдын судалгааны тайлан.

4. "Өнөөдөр" сонин. 2005.04.19.
5. "Өнөөдөр" сонин. 2004.09.20.
6. "Өрхийн үйлдвэрлэл" сэтгүүл 2003. № 06.
7. Радионуудын нэвтрүүлгүүд.
8. Телевизүүдийн нэвтрүүлгүүд.
9. Төрийн албан ёсны хэлний тухай хууль. 2003.
10. А в а н е с о в Р. И. 1972. Русское литературное произношение. М.

Resume

There are clauses in the law on State official language such as "Public media pursues language degree of Mongolian contemporary literature and terminology", "Press officer of public media has capacity and appropriate knowledge to use Mongolian language degree and its terminology".

But, speech culture of Radio and Television broadcast and its host is broken because of professional requirement is not put to them and an appropriate degree also is not put. Therefore, famous people in especially people who show their good model to teenager and youth need to pay attention to their speech when they have interview and host program.

Public media and art have an affect on the speech culture and user of public in especially children, teenager and youth. So that, it is need to organize multi-sided activity towards fixing, training and developing, putting control and imposing responsibility.